

## ЭРТНИЙ МОНГОЛЫН ТӨР, ШАШНЫ ХАРИЛЦААНЫ ТҮҮХЭЭС

*Д.Батаа\**

Төр шашин, сүм хийдийн харилцааны асуудлыг тал бүрээс нь судлан шинжлэх явдал өнөө үеийн нэгэн чухал асуудал билээ. Монголын төр, шашны харилцаа түүхэн үе бүрт нэгэн түвшинд байгаагүй нь тодорхой бөгөөд энэ олон талт асуудлыг энд төр, эрх зүйн талыг нь иш үндэс болгон илэрхийлэхийг зорьлоо.

### Монгол нутагт байсан эртний улсуудын үеийн төр ба шашны харилцаа:

Монголд бөө мөргөл давамгайлж байсан эртний улсуудад хүмүүс байгальтайгаа болон нийгэмтэйгээ их төлөв домгийн шинжтэйгээр тэнгэр шүтэх ёсны ердийн ухамсар, хэв заншлаар холбогдож, тэр нь төрийн хөгжилд зохих нөлөө үзүүлсэн байна. Онгон шүтээнийг монголчууд ан агнаж амьдарч байсан тэр цагаас эхлэн шүтэж, дараа нь малыг барьж тэжээн өсгөх болсноос хойш онгон шүтээн тахиx нь улам их болжээ. Овгийн байгууллын үед онгон шүтээн хамгийн их байсан тул тэр үед онгон шүтээн нь овгуудын холбоог нягтруулах явцад тус болжээ.

Манай эриний өмнөх 1760 оноос 1122 оны хооронд тогтож байсан Хятадын Ин улсын үе дэх Ша улс бол тэр үеийн нүүдэлчин овгуудаас бүрдсэн улс байсан. Хятадын түүхэнд Хүннү улсын удам бол Ша улс гэж тэмдэглэсэн байдаг.<sup>1</sup> Иймд Монголын онгон шүтээний тухай судлахад эрхбиш энэ үеэс эхэлж сонирхоx нь зүйтэй бизээ. Ши Жи-гийн Хүннү улсын тэмдэглэлийн тайлбарт Цзүй-Хао хэмээх “баруун талын нүүдэлчин аймаг цөмөөр лууг шүтнэ. Иймээс тахилга явуулдаг газрынхаа нэрийг луу хот гэж нэрлэсэн” гэж тайлбар бичжээ.<sup>2</sup> Мөн хойд Хань улсын бичгэнд “Хүннү улс 3 луут сүмд тахилга явуулдаг байсан”<sup>3</sup> гэх мэтээр бичжээ. Хань улсын хаан У-ди-гийн үед Хүннү улсын довтолгооныг бут цохиж, Хүннү улс нь хоёр тасарч зарим хэсэг нь баруун тийш нүүдэллэн зарим хэсэг нь Хятадад дагаар орсон. Энэ үед Хүннү улсаас маш олон хүмүүс олзлогдсоны дотор удган бөө нар их байсан гэж Хань улсын түүхэнд тэмдэглэжээ.<sup>4</sup>

Дээрхи материалуудаас үзвэл Ша улс, Хүннү улс нь лууг шүтэж өөрийн омгийн “Онгон шүтээн” болгож байжээ. Энэ нь Монголчуудын хамгийн эртний онгон шүтээнтэй холбоотой мэдээ бизээ. Монголчууд энэ мэтээр луу, буга, чоно, шонхор зэрэг тотем шүтэж байжээ. “Чингис хааны уг гарал болох Бөртэ-чино, Гуа-марал хоёр бол хаан хатан хоёр бус харин онгон шүтээн болсон араатан амьтны нэр”<sup>5</sup> гэж Ц.Дамдинсүрэн бичсэн байна.

\*Д.Батаа - Орхон их сургуулийн төр захиргааны эрх зүйн тэнхимийн эрхлэгч, докторант

“Ноён уулын булшийг ухахад Гуа-маралын зурагтай дэвсгэр олдсон бөгөөд энэ нь дээр үед монголчууд бугыг шүтдэг байснаас түүний зургийг эд хогшил дээрээ хадгалдаг байсан”<sup>6</sup> гэж японы эрдэмтэн Учида бичсэн байна. Хүннү нар жилд 3 удаа тахилга хийж, өвгөд, тэнгэр, дэлхий, онгон хайрхалад тахилга үйлдэнэ, тэрчлэн “шаньюй өглөө ордоноосоо гарч ургах наранд, орой саранд мөргөнө”, “нохой, могой өдөр эрхэмлэдэг” гэсэн нь хүннү нар бөөгийн шашинтай байсныг гэрчилж байна. Шаньюйг өвдлөө гэж хятадаас олзлогдсон том жанжинаар хүннүгийн бөө хойлого хийсэн байдаг. Хүннү улсын бөөгийн мөргөлийн талаар дээрхи жишээ баримтуудыг дурьдсан нь Хүннүгийн хаант улсад бөөгийн шашны нөлөөлсөн нөлөөллийг тодруулахыг зорьсонд оршино. Хүннү улс нь эзэн хаантай байж, түүнийгээ “тэнгэрээс заяат” гэж өргөмжилж байсан. Энэ нь бөөгийн шашны үзлээр хааныг “тэнгэрийн хүү” хэмээн шүтэж, ганцаар захирах дээд эрхийг зөвтгөн, захирах захирагдах ёсны үзэл төлөвшихөд нөлөөлсөн. Хүннү нар бөөгийн шашны гарцаагүй онцлог болох бөөгийн онгоныг шүтэх зэрэг заншилтай байгаа нь Хүннүчүүдийн дунд бөөгийн шашны хөгжил дээд зэрэгтэй хөгжиж, төрийн шашин болохуйц хандлагатай болсныг гэрчилнэ. Хүннү /МЭӨ209-МЭ93/ улсын дараагаар монгол нутагт нутаглаж байсан Сяньби /МЭ93-330/, Жужан /МЭ330-555/, Түрэг /МЭ555-745/, Уйгар /МЭ745-840/, Киргиз /МЭ840-917/, Кидан /МЭ917-1125/ улсууд ч нэгэн адил бөөгийн шашинтай байжээ.

Гэхдээ Монголын эртний улсуудад бөөгийн мөргөл дангаараа ноёрхож байсангүй. Монголын түүхийн сурвалж бичгүүд, түүх судлаач эрдэмтдийн бүтээлүүдээс үзэхэд Монголын эртний улсуудад бөө мөргөлийн зэрэгцээгээр Бурханы шашин дэлгэрч нийгмийн амьдралд үзүүлэх нөлөө нь лавширсаар байсан байна. Түүхийн явцын эрхээр Дундад Азийн ард түмэнтэй шууд холбоо тогтоосон ард түмний нэг бол Хүннү байжээ. Маодун шаньюийн үеэс Лоб нуур дахь Лоулань /Крорайна/, Долоон гол дахь усунь, Алтай дахь хуцзе, тэдний зэргэлдээх улсууд, нийт 26 орныг хүннү нар эзэлжээ.<sup>7</sup> Ингээд Хүннү нар наад зах нь МЭӨ 2-р зуунаас эхлэн бурханы шашныг шүтэгчид буй болсон улс орнуудтай улс төр, эдийн засгийн өргөн холбоо харилцаатай болсон байна. Хүннүгийн хараат байсан Куча бүр МЭӨ 109 онд бурханы шашинтай орон болжээ. МЭӨ 77 онд Хүннүгийн элч Усунийг дайран Кучад очсон байна.<sup>8</sup>

Сяньби нарт Төв Азийн бусад нүүдэлчин аймгуудын адил бөөгийн шашин хүчтэй байсан нь илэрхий байгаа нь Таньшихуайн /136-181/ үед сяньби нар Жаоле голд очиж, их тахилга үйлддэг байснаар илэрнэ. Ноёлогч нар бөөгийн шашныг өөрсдийн эрх ашигт зохицуулан ашиглаж байжээ. Хүннү нарт бурхан багшийн алтан хөрөг байсан нь хүннүгийн ноёлогч нар бурханы шашныг шүтэж байсныг гэрчилнэ. Хүннүгийн тэр

хөргийн эзэн аймаг нь Яо Вэй-ноань зэрэг эрдэмтдийн нотолсноор сяньбийн тугухунь аймаг байжээ. Ингэхлээр сяньби нарын ноёлогч хэсэг нь бас бурханы шашныг мэддэг, сүсэглэдэг байжээ гэж үзэж болохоор байна. Хүннү, сяньби, тугухунь, тоба нарын шашин шүтлэгийг улируулан ажваас бурханы шашин ямар нэгэн хэмжээгээр ноёрхогч давхаргынханд байсаар байсан байна. Тэр нь хожим тугухунь, тоба нарт бурханы шашин дэлгэрч, ялангуяа Их Вэй улсын хааны 398-399 оны зарлигт бурханы шашныг дэлгэрүүлэн суврага босгохыг дурьдаж байжээ.<sup>9</sup> Мөн Их Вэй улсын Тоба Гуй хаан /386-409/ “дао-жэнь-тун” гэдэг лам нарын захиргааг байгуулан түүний тэргүүнээр Фаго гэгч ламыг томилж байсан байна. Эзэн хаан нь лам нарын тэргүүнийг томилдог байсан болохоор тэр тэргүүн нь хаан төрийн гишүүн болж, төрийн зарлигийг дагах ёстой байсан.<sup>10</sup>

Ийнхүү Тобагийн Их Вэй улс байгуулагдсан эхэн үеэс эхлэн төр, номын хоёр ёсон тобагийн хаадын төрийн бодлогын нэгэн гол зүйл болж байжээ. Ингэж төр, шашныг хослон барих төр, номын хоёр ёсон нь Төв Азийн нүүдэлчин аймгуудад тобагийн Их Вэй улсын үеэс эхэлсэн байна. Эрдэмтэн Г.Сүхбаатарын судалгаанаас үзэхэд МЭ-ний 400-гаад оноос Монгол нутагт үүссэн Нирун улсад бөө мөргөлийн зэрэгцээгээр бурханы шашин дэлгэрч байжээ.

Нирун улсаас Тоба-Вэй улсад лам хүнийг элчээр явуулж байсан ба Нирун лам нар Тоба-Вэй улсад очиж бурханы шашны ном үзэж, тэнд Энэтхэгээс ирсэн лам нартай уулзаж танилцаж байжээ. Үүнээс үзэхэд Нирун улсад Бурханы шашин ямар нэг хэмжээгээр нэвтэрч байсан ажээ.<sup>11</sup> Нируны хаад нь бурханы шашны сургаал ёсоор Ашид амгалан /464-485/, Машид түвшин /485-491/, Машид тайван /491-506/, Эхэн түвшин /506-508/, Мандан бадрах /508-520/ гэх мэтээр хэдэн оны цолтой байсан. Нируны хаан бурханы шашны номд мэргэжсэн лам Дармаприяг төрийн багшаар томилон 3000 өрх соёрхон төр, шашныг хосолсон хос ёсыг хэрэглэсэн. Энэ нь бүр Хүннүгийн үеэс бурханы шашны сургаалын үндсэн дээр хааны засгийг ариусган эхэлж, улмаар Сяньби улсыг дамжин Нирун улсын үед бүрэн биелэлээ олжээ.

Эртний Энэтхэгийн Наландарын олон Ачирья гадаад орнуудад Буддын сургаалыг заан дэлгэрүүлж байсан төдийгүй төрөлхи сургуульд нь гадаадын олон суралцагч сурч байснаараа “олон улсын их сургууль” байжээ. Хятадын жуулчин гэж түүхэнд алдаршсан Ху Фасен Наландарт 5 жил суралцсан бол түүнийг дагалдан явсан 5 шавийн нэг, Наландарт 10 жил суралцсан И чингийн тэмдэглэлд: Наландарт солонгос, монгол, тохар, хятад, түвд зэрэг орны оюутан сурагч байсан. Ийнхүү И чинг МЭ-ний 675-685 онд сурч байхад нь гадаад орны 56 суралцагч байсан гэж тэмдэглэжээ.<sup>12</sup> Нируны хаант улсад ийнхүү лам нар бусад улсад

төрийг төлөөлж, төрийн алба хашиж, Тоба-Вэй улсад бэлтгэгдэж, Энэтхэгийн “туршлага судалж” байсан зэргээс үзвэл эл улсад бурханы шашин төрд шууд нөлөөлхүйц хэмжээнд хөгжсөн бололтой.

1. Эртний улсуудын үед Монголчуудын уугуул шашин болох бөө мөргөл зонхилох байр суурьтай байсан боловч төрт ёс бэхжиж, хүчирхэг улсууд бий болж хаант засаг батжихын хирээр төрийн үзэл суртлын үүргийг бөө мөргөл дангаар гүйцэтгэх боломжгүй болжээ. Монголын хаад Энэтхэгээс Бурханы шашныг зөөвөрлөн дэлгэрүүлж Монголын төрийн үзэл суртал, оюун санааны үндэс болгох зүгт хөтлөн, улмаар “төрийн шашин” болгох эхлэл тавигджээ.

2. Монголын эртний төр улсуудын түүхэнд бурханы шашны номлол хүчтэй нэвтэрч, сүм хийдүүд үүсэн хөгжиж, сүсэгтнүүдийн дэмжлэг төрийн ивээлд хөгжин дэвжсэнээр энэхүү шашны байр суурь үлэмж бэхжив.

3. Монголын түүхэнд эртний төрт улсуудын үеэс Монголын төр, бурханы шашин хоёр зэрэгцэн орших уламжлал төр, шашны харилцааны түүхийн салшгүй нэгэн хэсэг нь болон үүсжээ. Энд бөөгийн тэнгэрийг шүтэх ёс бас хамт уламжлагдан буй болно.

4. Монголын төр бурханы шашныг ивээлдээ авч төрийн бодлого, үзэл суртлын эх үндэс болгохыг хичээж ирсэн боловч төрийн хэрэгт оролцохыг шашны зүгээс дэмждэггүй нэгэн үе байжээ. Төрийн зүгээс шашин, сүм хийд, лам нарын хэргийг хуульчлан баталгаажуулж, харин дотоод хэрэгт нь оролцдоггүй уламжлал тогтсон байна.

### Монголын нэгдсэн улсын үеийн төр ба шашин, сүм хийдийн харилцаа:

Их Эзэн Чингис хаан өөрийн харьяанд орсон өөр өөр иргэншил, соёл, шашин шүтлэгтэй үндэстнүүдийг Их гүрний захиргаанд нэгтгэн барьж байхын тулд шашныг ялгаварлахгүйгээр адил тэгш үзэх, хүн бүхэн өөрийн сүсэглэх шашнаа шүтэн бишрэх эрхийг хангах бодлогыг явуулж хууль тогтоож байсан. Энэ нь шашин хоорондын мөргөлдөөнөөс зайлсхийж, тэдгээрийн нөлөөг хаант төрийн ноёрхлыг бэхжүүлэхэд чиглүүлсэн ухаалаг бодлого байсан хэмээн үзэж болно. Гэхдээ Монголын нүүдэлчин овог, аймгууд өөрсдийн уугуул шашин, шүтлэгээ хадгалан байсан билээ. Өгөөдэй, Мөнх хаан зэрэг Монголын их хаад бөө мөргөлтэй байсан боловч Чингисийн шашны талаар баримталж байсан бодлогыг залгамжлан авч аль нэг шашныг онцлон тэтгэхгүйгээр адил тэгшээр хөхүүлэн дэмжиж байжээ. Тиймээс Хархорум хотод бөөгийн мөргөлөөс гадна бурханы болон исламын, христосын шашны сүм хийд, хурал номын газрууд зэрэгцэн байгуулагдсан байв. Монголын их хаад бөө мөргөлийн ёсыг голлон шүтэж, бусад шашинд эерэгээр хандаж байсан баримт түүхийн эх сурвалжуудад элбэг тааралддаг. Нэгэн жишээ дурьдахад: Мөнх хаан

Вельгелм Рубруктай шашны тухай ярилцахдаа: “Монголчууд бид цорын ганц бурхан байдаг гэж итгэдэг... гэвч бурхан хүний гарыг янз бүрийн хуруутай болгон бүтээсний нэгэн адил хүмүүст бас янз бүрийн зам зааж өгчээ...бурхан та нарт судар ном хайрласан, түүнийг нь та нар сахихгүй байна. Бидэнд оточ, төлөгч нарыг оноож өгсөн бөгөөд бид тэдний зааврыг дагаж мөрдөн энэ ертөнцөд амьдардаг...” гэсэн байдаг. Их хаалын энэ бодлого нь эзэнт гүрний харьяанд орсон бусад үндэстнүүдийн сэтгэл оюунд сэв суулгахгүйгээр шүтлэг бишрэлийг нь ашиглан эрхшээлдээ байлгах гэсэн төрийн нарийн бодлого, арга ухаан байсан. Монголын Эзэнт Гүрний үеийн төр, шашны харилцааны асуудал нь Монголын түүхэнд томоохон байр суурийг эзэлдэг. Чингэс хаан “Их засаг” хуулийг анх удаа 1189 онд, дараа нь 1206 онд буюу Чингис хаан их ор суух үед хуралдуулсан хуралдаанаар батлан тунхаглажээ. Чингис хаан тэр цагт хуучин хуулиудыг тэр бүр үүнээс хойш даган мөрдөж болохгүй тул урьд эдүгээгийн хуулиудыг хянан хэлэлцэж шинэчлэн тогтоох нь зүйтэй гэж үзжээ. Энэ үйл явдлын дараа 1210, 1218 онуудад тус тус хийлгэсэн хоёр удаагийн хуралдаанаар “Их засаг” хуульд дахин нэмэлт өөрчлөлт оруулах асуудал хэлэлцэж гаргасан зүйлээс уг хууль анхлан бүрдэл болсон тухай Персийн түүхч Рашид-Ад-Дин өөрийн зохиолдоо тэмдэглэсэн байдаг.<sup>13</sup> Монголын төр ёс, хууль цаазын энэхүү тулгуур сурвалжаар тухайн үеийн нийгмийн харилцааны бүхий л ээдрээ, төвөгтэй асуудлуудыг зохицуулж байсан бөгөөд түүнд төр, шашин, сүм хийдийн харилцааны асуудал ч мөн багтаж байв. “Их засаг” хуулийн шашинтай холбоо бүхий заалтууд нь аливаа шашинд адил хандаж байх, шашны эрхийг төр засгийн эрхээс ангил байлгахад чиглэсэн. Энэ нь шашныг ивээн хамгаалах, лам нарыг аливаа татвар болон феодалын төрийн өмнө гүйцэтгэх албан үүргээс чөлөөлж төрөл бүрийн шашныг хүндэтгэж байх болгожээ. Үүний хамт ямар нэгэн шашны онц эрх эдлэхийг хоригложээ. Аливаа шашныг адилхан үзэх болсон нь сүсэгтэн олны шүтлэгийг хүндэлж, эв найртай байх явдлыг харгалзсан хэрэг болно.

Өрнө дахинд төрийн үзэлд шашин давамгайлах үүрэг гүйцэтгэж байсан дундад зууны үед ч төр шашны харилцааны асуудал монголчуудын соёл, оюуны хүрээн дэх шийдвэрлэвэл зохих чухал асуудал болж байв. Судалгаанаас авч үзвэл Монголын эртний улсуудаас уламжилсан Монголчуудын гол шашин шүтлэг болох бөө мөргөл нь Эзэнт Гүрний үед ч төрийн хэмжээнд чухал үүргийг гүйцэтгэж байсны зэрэгцээ бас ард түмний ахуй амьдралд хүчтэй хэвээр үйлчилж байсныг түүх харуулж байна. Өвөр Монголын судлаачид, тухайлбал Г. Мөнхөө, Г. Гэрэлбаатар нарын бүтээлд Монголын Эзэнт Гүрний төрийн шашин болох мөнх тэнгэрийн шүтлэг нь бөө мөргөлөөс үүдэлтэй бөгөөд түүнийг бодвол илүү өргөн хүрээтэй хөгжлийн дээд шатанд хүрсэн монотейст шашны хэмжээнд

хүрсэн мөнх тэнгэрийн шүтлэг байсан гэсэн санаа дэвшүүлсэн нь сонирхол татсан нягтлууштай дүгнэлт юм. Мөнх тэнгэрийн шүтлэг нь Монголын Эзэнт Гүрний төрийн шашны хэмжээнд хүрч, Монголын Эзэнт Гүрнийг байгуулахад үзэл суртал нь болж, монголчуудыг оюун санааны эв нэгдлээ илэрхийлэхэд нь гол цөм хөдөлгөгч хүч нь болж байсан гэж үздэг зарим судлаачидтай зарчмын хувьд нэг байр суурьтай байгаа болно. Чингис хаан төрийг авч үзэхдээ төр бол мөнх тэнгэрийн ивээл учраас төр нь шашинд бус харин шашин төрд үйлчлэх ёстой гэж үздэг байв. Түүхийн ухааны доктор О.Пүрэвийн тооцоолсноор Чингис хаан нийт 14 удаа Мөнх тэнгэрийн зарлигыг дамжуулснаас 3 удаад нь л бөөгөөр дамжуулан хэлсэн байх бөгөөд “Их засаг” хуульд хүн бүр өөрийн шүтдэг шашнаа шүтэж болно гээд шашны эрх чөлөөг хуулийн хүрээнд “...аливаа шашин суртахууныг хүндэтгэмой, гэвч ямар нэг шашинд онцгой эрхийг өгч үл болмой” гэж хуульчлан зааж өгчсөн. Эндээс Чингисийн дараахи их хаадын шашинд хандах хандлага харьцаа тодорхойлогджээ.

Төрөөс шашинд хандах энэ хандлага Хубилай хааныг хүртэл үргэлжилсэн билээ. Монголын Эзэнт Гүрний үеийн төр нь аливаа шашинд хүндэтгэлтэй хандаж хориг саад тавьж байсангүй. Монголын хаадууд зөвхөн мөнх тэнгэрийн хүчинд л сүсэглэж төр бол зөвхөн мөнх тэнгэрт захирагдахаас бус дэлхийн бусад аливаа шашин нь төрийг захирахгүй гэж үзэж байв. Энэхүү үзэл санаа нь аливаа шашны нөлөөг төрөөс тусгай байлгах, шашин шүтлэг нь зөвхөн төрд л үйлчлэх ёстой гэж үзэж байсантай холбоотой. Монголын Нэгдсэн Улс буюу Чингисийн Эзэнт Гүрний үед ч тэнгэрийг шүтэх ёсон бурханыг шүтэх үзэл хоёр зэрэгцэн оршиж байсан бөгөөд харин бурханыг шүтэх нь Мөнх тэнгэрийг шүтэх хэлбэртэй хосолж байжээ. Өөрөөр хэлбэл Монголын эртний улсуудаас эхлээд эзэнт гүрний үеийг хүртэлх урт хугацаанд Монголчуудын тэнгэрийг шүтэх ёсноос бурханчилсан хэлбэрийн шүтлэгт шилжих үйл явц үргэлжилсэн бөгөөд үүнд өнө эртнээс Монголд дэлгэрсэн бурханы шашны нөлөө багагүй байсан байна гэж үзэх үндэстэй юм. Шилжилтийн шинжтэй энэ үйл явц нь монголчуудын нийгмийн ухамсарт гарсан өөрчлөлт, төр, шашны харилцааны өвөрмөц байдлыг гүнзгий тусгаж байлаа. Монголын төрийн мандал бадралын нэгэн оргил үе, XII-XIV зуун буюу Эзэнт гүрний үеийн Монголын гүн ухаан, нийгэм улс төрийн сэтгэлгээн дэх төр, сүм хийдийн харилцааны асуудлыг хөгжлийн өнгөрсөн, одоо, ирээдүй, улс орны дотоод, гадаад нөхцөл байдалтай холбон өргөн хүрээтэй авч үзэх нь чухал. Чингис ба түүний дараахи хаанчлалын үед Монголд төр шашныг хослон барих тухай үзэл дэлгэрч төрийн бодлого болтлоо боловсорч, амьдралд нэвтэрч эхэлсэн байна. Монголын тулгар төрийн үед Чингис хааны хамтран зүтгэгчид монгол цэргийн эрхтнүүдийн ашиг сонирхлыг уламжлалт бөөгийн шашин илэрхийлж байсан бол хэрэйд, найман, хар

киданы гаралтай ноёдын дунд, доод давхраа, уйгарын худалдаачдын дунд христосын шашин зонхилж байсан.<sup>14</sup> Ийм нөхцөлд Чингис хаан олон түмний сүсэг бишрэлийн асуудлыг өөрсдийнх нь эрхийн хэрэг гэж үзэн “Их засаг” хуулинд “Аливаа шашин суртахууныг хүндэлмой.”<sup>15</sup> гэж бататгаж өгсөн. Хүн төрөлхтөний төрт ёсны түүхэнд бүх шашныг нэгэн адил үзэж хамгаалдаг, тэдгээрийг бүгд адил тэгш эрхтэй байлгадаг төр гэж байгаагүй. Монголын их, бага хаад тэдний үеийн хууль цааз, эрхэмжийн дурсгалт бичгүүдэд нэг талаас эзлэгдсэн улсуудын хүн амыг өөр өөрсдийн шашин суртахуунаа шүтэн бишрэхийг зөвшөөрч, нөгөө талаас уламжлалт бурханы шашныг төрийн шашин болгох бодлогыг тууштай явуулсан байна. “Их засаг” хууль нь XIII зууны эхэн үед Монголын нийгмийн хууль цаазын сэтгэлгээний хөгжилд чухал үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ феодалын үеийн Монголын хууль цаазыг шинэчлэн өөрчлөхөд уламжлал болсон түүхэн ач холбогдолтой юм.

### ИШЛЭЛ, ЗҮҮЛГ:

1. Шижи, Шүнну жуань-шижи гэдэг судрын хүннүгийн тухай хэсэгт.
2. Цүэй-хай гэдэг хүн Хань улсын үед Ши жи-д тайлбар бичжээ.
3. Хоу Хань шу-д хойд Хань улсын түүх, хүннүгийн хэсэгт.
4. Хоу хань шу-хань улсын түүх, 94-р бүлэг, Хүннүгийн тухай.
5. “Монголын уран зохиолын түүх” Ц.Дамдинсүрэн, бөө мөргөлийн яруу найраг /хуучин монголоор/х-123.
6. “Эртний Монгол” гэдэг номондоо эрдэмтэн Учида монголын эртний зан суртахуун. Хэв заншлын тухай нилээд бичсэн байдаг.
7. Централная Азия в Кушанскую эпоху /Труды международной конференции по истории, археологии и культуре Центральной Азии в Кушанскую эпоху. Душанбе. 27.9-6.10.1968/ т-1.М.1973.стр-199.
8. Liu Mau-tsai. Kutcha und seine Beziehungen zur China vom.2. Jh.v. biszum 6. JH.n. Chr. ВВ. I. II. Wiesbaden. 1969. p. p-40.
9. J.R.Ware.Wei Shou on Buddhism. “Toung Pao”.vol. XXX.N1-2. 1933. p.p-128.
10. Kennet Chen. On some factors responsible for the antibuddhist persucation under the Pei-chao. “Harvard Journal of Asiatic studies” vol.17 N1-2. 1954. p.p-271.
11. БНМАУ-ын түүх,3 боть,Тэргүүн дэвтэр, УБ, 1966, 1967, 1968, х-118.
12. Буддын сургаал ба шинжлэх ухаан, Б. Болдсайхан, УБ, 2003, х-63.
13. Рашид-Ад-Дин. Судрын чуулган. 1-р боть 2-р дэвтэр 77, 185, 272-р тал.
14. Ч.Жүгдэр, Монголд феодализм тогтох үеийн нийгэм улс төр, гүн ухааны сэтгэлгээ,УБ,1987,х-191.
15. Төр,сүм хийдийн харилцаа, орчин үе, УБ,1998,х-72.